

**АЙМГИЙН ИТХТ-ИЙН 2020 ОНЫ 91 ДҮГЭЭР ТОГТООЛЫН ХАВСРАЛТ
"ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АЖЛЫН ХЭСЭГТ ИРҮҮЛЭХ, МЭДЭЭ,
МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ"-Д СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН САЛБАРЫН
ЧИГЛЭЛЭЭР ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ**

2023.12.06

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАНДАРТЫГ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН
ТҮВШИНД НИЙЦҮҮЛЖ БАЙГАА ТАЛААР**

Аймгийн хэмжээнд жилдээ нийт 130 гаруй ААН, иргэний худалдааны газар, хоолны газар, зочид буудал, зоогийн газар, интернэт цахим тоглоомын газар, амралтын газар, жуулчны бааз зэрэг газрууд баталгаажуулалтад хамрагддаг. Баталгаажуулалтын явцад зөрчил дутагдалтай газруудад тухайн үйлчилгээний стандартаар зөвлөгөө өгч стандартын шаардлага хангуулан ажиллаж байна.

Баталгаажуулалтын схемийн зорилго:

Зах зээлд нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, тогтолцоо нь тогтоосон нэг ижил шаардлага, журмын дагуу холбогдох баримт бичиг, стандартын шаардлагад нийцсэн эсэхийг тогтоох замаар тохирлын үнэлгээ явуулахад оршино.

Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт нь тогтоосон шаардлагыг хангаж буйг харуулсан үнэлгээ болон бие даасан гуравдагч талын /баталгаажуулалтын байгууллагын/ үнэлгээний дүгнэлт юм. Бүтээгдэхүүний баталгаажуулалтыг итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага гүйцэтгэнэ.

Заавал баталгаажуулалт / 13.2 дах заалт/

Тохирлын үнэлгээнд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт

1.	Үс засах	MNS 5160:2020
2.	Гоо сайхан	MNS 5567:2006
3.	Халуун ус	MNS 5163:2002
4.	Саун	MNS 5164:2010
5.	Хими цэвэрлэгээ	MNS 5353:2004
6.	Нийтийн тээвэр	MNS 5879: 2012
7.	Зочид буудал	MNS 4588: 2008
8.	Жуулчны бааз, амралтын газар	MNS 6043: 2019

9.	Нийтийн хоолны газар	MNS 4946: 2019
10.	Хүнсний дэлгүүр, хүнсний бүтээгдэхүүний бөөний худалдаа	MNS 5120:2019
11.	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ	MNS 5274: 2017
12.	Хүүхдийн зуслан	MNS 5633: 2013
13.	Бассейн	MNS 6182: 2010
14.	Чийрэгжүүлэлт, алжаал тайлах төв	MNS 5538: 2005
15.	Хүүхдийн тоглоомын газар	MNS 6430: 2014
16.	Шуудангийн үйлчилгээ	MNS 5382-1:2004

Хамрах хүрээ

- Дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүний баталгаажуулалт
- Үйлчилгээний баталгаажуулалт
- Импортын бүтээгдэхүүний баталгаажуулалт;
- Экспортын бүтээгдэхүүний баталгаажуулалт;
- Тогтолцооны баталгаажуулалт; (ISO 9001, ISO 14001, ISO 22000, ISO 18001, HACCP)
- “Үндэсний тохирлын тэмдэг” хэрэглэх эрх олгох;
- Аюулгүйн тэмдлэг хэрэглэх эрх олгох

Сайн дурын баталгаажуулалт / 13.3 дах заалт/

ХОЁР. МОНГОЛ УЛСАД МӨРДӨГДӨЖ БУЙ ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ ТАЛААР



Орон нутаг дахь Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулиар стандартын салбар сан ажиллуулж стандарт борлуулах, стандартын мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлдэг. 2023 оны жилийн эцсийн байдлаар Иргэд, ААН, байгууллагуудын захиалгаар 1,493,040 төгрөгийн үнэ бүхий 62 стандартыг түргэн шуурхай гарган өгч үйлчилсэн.

Эрүүл мэндийн салбарын стандарт - 24

Барилгын салбарын стандарт - 3

Хүнсний стандарт - 12

Үйлчилгээний - 23

Мөн шинээр батлагдсан стандартын мэдээллийг цахимаар болон СХЗХ-ээр үйлчлүүлж буй иргэдэд хүргэн ажиллаж байна. Мөн хүчингүй болсон стандартын талаар мэдээллийг байгууллагын цахим хуудсаар болон байгууллагын албан ёсны пейж хуудсаар дамжуулан хүргэж байна.

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТЭС